

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.

2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Чулуун зэвсгийн үеийг дотор нь хуучин, дунд, шинэ чулуун зэвсэг гэж хуваадаг. Тэгвэл аль үе нь доод, дунд, дээд гэсэн үе шатуудтай вэ? /1 оноо/  
A. Палеолит B. Мезолит C. Неолит  
D. Энеолит E. Эдгээрээс өөр
2. Палеолитын /хуучин чулуун зэвсэг/ үед холбогдох хамгийн эртний хадны зураг аль нь вэ? /1 оноо/  
A. Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын хадны зураг  
B. Увс аймгийн Сагил сумын Могоогийн хадны зураг  
C. Ховд аймгийн Үенч сумын Ямаан усны хадны зураг  
D. Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуйн хадны зураг  
E. Дорнод аймгийн Булган сумын Норовлингийн онго
3. Буган хөшөөний талаарх бодомжуудаас буруу өгөгдлийг олно уу? /1 оноо/  
A. Оройн хэсэгт нь нар, сар  
B. Дунд хэсэгт бугыг голдуу дүүлж, тэмүүлж байгаагаар дүрсэлдэг.  
C. Доод хэсэгт зэр зэвсэг  
D. Буганаас гадна янгир, адуу, шувууг дүрсэлдэг.  
E. Буга агнаж байгаа хүн
4. Эртний хүмүүсийн хөдөлмөрийн нийгмийн анхны хуваарь аль нь вэ? /1 оноо/  
A. Хөдөө аж ахуй, газар тариалан B. Ан агнуур, мал аж ахуй  
C. Арилжаа, гар урлал D. Худалдаа, тээвэр  
E. Ан агнуур, хөдөө аж ахуй
5. Эртний Сяньби улс оршин тогтнож байсан цаг хугацааг тодорхойлно уу. /1 оноо/  
A. НТӨ 209-НТ 93 B. НТ 330-555 C. НТ 745-840  
D. НТ 840-923 E. НТ I-III зуун
6. “Хөрш аймгийн довтолгооны эцэст гар хөлөө тайруулаад амьд үлдсэн 10 настай өнчин хүүтэй өлөгчин чоно учирч, тэдний дундаас 10 хөвгүүн төржээ. Тэднээс 10 овог үүссэний нэг нь Ашина овог байжээ”. Энэхүү домог нь эртний улсуудын алинд хамаарах вэ? /1 оноо/  
A. Уйгур B. Хятан C. Киргиз D. Түрэг E. Жужан
7. Хүннү улсын соёлд дараах түүхэн өгөгдлүүдээс аль нь хамааралтай вэ? /1 оноо/  
A. Хар балгас, уйгаржин бичиг  
B. Хоёр ёсны үзэл, хаан цол, Мөөмт хот  
C. Их, бага бичиг, гэрэгэ пайз, суврага  
D. Ясан хэл хуур, 12 жилийн тоолол, бөө мөргөл  
E. Энд тийм зүйл дурдаагүй байна.
8. Нирун улсын хаадаас түүх, газарзүй, одон орон, зурхайн ухаан, бурхны шашны ном, сургаал судалдаг, “Хутагтай сэцэн” хэмээн өргөмжлөгдсөн төрийн зүтгэлтэн аль нь вэ? /1 оноо/  
A. Шэлүнь B. Билгэ C. Пейло D. Можа E. Кэбинин

9. Энэхүү түүхэн дурсгал эртний аль улсад хамаарах вэ?

/2 оноо/

- A. Хүннү
- B. Нирун
- C. Түрэг
- D. Уйгур
- E. Хятан

10. Татарын ханлигт хамаарах Монгол аймгууд хаагуур төвлөрөн аж төрж байсан бэ? /1 оноо/

- A. Байгаль нуурын баруун биеэр
- B. Ононгийн адаг
- C. Хөлөн Буйр нуур
- D. Алтайн нуруу
- E. Эрчис мөрөн

11. Монголын Дарлигин салбар хэний үеэс хойш ноёлох байр сууриа Нирун салбарт алдсан бэ? /1 оноо/

- A. Добу мэргэн
- B. Торголжин баян
- C. Боржигдай мэргэн
- D. Хоричар мэргэн
- E. Харчу

12. Монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов нар нийт Монгол аймгуудыг хэрхэн хоёр хуваасан байдаг вэ? /1 оноо/

- A. Язгууртан ба харц
- B. Нүүдлийн ба суурин
- C. Унаган ба өтөгү
- D. Тариаланч ба урчууд
- E. Ойн иргэн ба талын нүүдэлчин

13. 1084 онд Хамаг Монголыг хятад сурвалжид “Да Мэн-гу” гэж тэмдэглэснийг зууны тоололд шилжүүлсэн зөв илэрхийлэл аль нь вэ? /2 оноо/

- A. XI зууны II хагас
- B. XI зууны I хагас
- C. XII зууны II хагас
- D. XIII зууны II хагас
- E. XII зууны I хагас

14. Найманы ханлигийн хан хэн бэ? /1 оноо/

- A. Хөгсү Сабраг
- B. Хабул хан
- C. Тоорил хан
- D. Таян хан
- E. Тогтао бэхи

15. 1201 онд Тэмүжин, Жамуха хоёрын хооронд шийдвэрлэх тулалдаан хаана болсон бэ? /1 оноо/

- A. Сэлэнгийн буур хээр
- B. Мау өндөр
- C. Зээрэн хавцал
- D. Хэрлэнгийн доод урсгал Хүйтэн
- E. Алтайн нурууны Наху гүн

16. Их Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын талаарх зөв бодомжийг олно уу. /2 оноо/

- A. Төрийн бэхи нь их хуралдай хуралдуулах, хаан өргөмжлөх, аян дайнд мордох зэрэг төрийн чухал үйл хэрэг эхлэх өлзийт өдрийг сонгон цаг, зүг чигийг заана.
- B. Хөхөчү бөө буюу Тэв тэнгэр нь хааны итгэлийг олж бусад зайран, удганаас дээгүүр байр суурь эзэлж байсан.
- C. Шихихутаг бол Их Монгол улсын анхны Их заргач мөн.
- D. Боорчи, Зэлмэ, Сорхон шар нарын Их Монгол улс байгуулахад амь биеэ хайрлалгүй зүтгэсэн хүмүүсийг “Дархан” болгосон.
- E. Дээрх бүгд зөв бодомж

17. Чингис хааны дөрвөн нохос буюу жанжид аль вэ? /2 оноо/

- A. Мухулай, Боорчи, Борохул, Чулуун
- B. Шихихутаг, Даридай, Чуу мэргэн, Хар хирүгэ
- C. Сорхон шар, Тэмүгэ, Их Чэрэн, Хөхөчү
- D. Мэнлиг, Нэгүүн, Жаха хамбу, Хүчү
- E. Зэв, Сүбээдэй, Зэлмэ, Хубулай

18. “Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг. Түргэн! Мөхөс өөрийн бие явсан адил зохисыг үзэж шийтгэсүгэй. Мөнх тэнгэрийн дор хэн эс биширвээс үхэх” гэсэн бичээс аль түүхэн эх сурвалжид хамаарах вэ? /2 оноо/  
A. Гүюг хааны тамганы бичээс  
B. Гэрэгэний бичээс  
C. Чингисийн чулууны бичиг  
D. Аргун хаанаас Францын гоо Филиппт бичсэн захидал  
E. Тохирох хариулт алга
19. Чингис хаан аль хүүдээ Дорнод Туркестан, Казах, Хорезм, Мавереннахр, Афганистан, Дундад Азийн эзэлсэн газар нутгаа хувь буюу эзэмшил болгон өгсөн бэ? /1 оноо/  
A. Зүчи  
B. Цагаадай  
C. Өгөөдэй  
D. Тулуй  
E. Хүчү
20. Хүлэгү хааны зарлигаар түүний зөвлөх Насир-ад – Динат гүш Тебризийн хойд талд ..... судлалын төв байгуулжээ. /1 оноо/  
A. Одон орон  
B. Түүх  
C. Археологи  
D. Шашин  
E. Соёл
21. Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагаанд хамаарах зүйлийг нэрлэнэ үү. /2 оноо/  
1. Морин өртөөг анх байгуулсан.  
2. 1269 онд Пагва ламаар дөрвөлжин үсгийг зохиолгосон.  
3. Хаант төрийн хос ёсны сургаалыг хөгжүүлсэн.  
4. Говь газар худаг гаргаж, хүн, амьтныг ундаалсан.  
5. Уйгаржин монгол бичгийг төрийн бичиг болгосон.  
6. Хархорум хотыг өргөтгөсөн.  
7. Өөрийн нутгийн ан гөрөөсийг бусдын нутагт оруузай хэмээн хашаа, хэрэм бариулсан.  
A. 1, 4  
B. 1, 5  
C. 1, 6  
D. 1, 7  
E. 2,3
22. Өгөөдэй хааны “Түмэн Амгалант” орд өргөө хаана байсан бэ? /1 оноо/  
A. Хархорум  
B. Ханбалиг  
C. Кайпин  
D. Сарай  
E. Самарканд
23. ..... онд Хубилай хаан Бээжингийн зүүн хойно бариулсан шинэ нийслэл Ханбалигт шилжин суусан. Хэдэн онд болсон үйл явдал вэ? /1 оноо/  
A. 1264  
B. 1267  
C. 1271  
D. 1294  
E. 1368
24. Зүчийн ахмад хөвгүүн Бат аль улсыг үндэслэгч вэ? /1 оноо/  
A. Ил хаант улс  
B. Алтан ордны улс  
C. Цагаадайн улс  
D. Юань улс  
E. Крымийн хант улс
25. Ил хаадын улсын түүхэнд холбогдох өгөгдлийг нэрлэхдээ буруу зүйл оруулсан байна уу? /1 оноо/  
A. Султани хот  
B. Үндэслэгч нь Хүлэгү  
C. Ханбалиг хот  
D. Газан хааны шинэчлэл  
E. Түүхч, сайд Рашид-ад Дин
26. Монгол улсын түүхэнд улс төрийн бутрал аль үед тохиосон бэ? /1 оноо/  
A. XIV-XVII зуун  
B. XIV-XVIII зуун  
C. XIX зуун  
D. XVIII-XIX зуун  
E. XX зуун
27. “Дөрвөн Ойрад”-ын түмэнд аль нь үл хамаарах өгөгдөл вэ? /2 оноо/  
A. Чорос  
B. Хошууд  
C. Торгууд  
D. Дөрвөд  
E. Ордос
28. Сурвалжид “Дөчин дөрвөн хоёр нэг хааны алдар болов” гэж тэмдэглэсэн байдаг. Энэ нь аль хааны үе вэ? /2 оноо/  
A. Мандуул  
B. Эсэн  
C. Батмөнх  
D. Аюушридар  
E. Лигдэн

29. Мандухай сэцэн хатан алтан ургийн ноёдын дэмжлэгтэйгээр 1466 онд Батмөнхийг 7 настайд нь хаан ширээнд залжээ. Түүхэнд Батмөнх хаан ямар цолоор алдаршсан бэ?

/1 оноо/

- A. Засагт хаан  
D. Хутагт хаан
- B. Эсхи хаан  
E. Даян хаан
- C. Усхал хаан

30. Бичиг үсгийн тухай ойлголтуудыг тохируулна уу.

/2 оноо/

- A. 1587 онд Аюуш гүүш  
B. 1648 онд Зая бандид  
C. 1686 онд Занабазар
1. Галиг үсэг  
2. Тод үсэг  
3. Соёмбо үсэг

- A. a1, в2, с3      B. a1, в3, с2      C. a2, в1, с3      D. a3, в1, с2      E. a3, в2, с1

31. 1691 оны 5 сард Халхын 550 гаруй ноёд тайж нар, Өвөр Монголын 49 хошууны нөлөө бүхий ноёдыг оролцуулсан чуулганаар Халхыг Манжид дагаар орох ёслол хийжээ. Энэ нь аль чуулганаар болсон үйл явдал вэ?

/2 оноо/

- A. Долнуурын чуулган  
C. Ар Элстэйн чуулган  
E. Хүрэн бэлчирийн чуулган
- B. Ширээ цагаан нуурын чуулган  
D. Мүгдэний чуулган

32. “Эх орноо хамгаалах үйлсэд эр бие, энэ нас хайрангүй” гэж хэн хэлсэн бэ?

/1 оноо/

- A. Хойдын Амарсанаа  
C. Чоросын Галдан
- B. Хотгойдын Чингүнжав  
D. Цахарын Лигдэн
- E. Хошуудын Төрбайх

33. 1757 оны 6 сарын 30-нд Амарсанаа болон Манжийн их цэргийн жанжин Халхын Цэнгүнжав нарын хооронд шийдвэрлэх тулаан хаана болсон бэ?

/2 оноо/

- A. Ац амттай  
D. Шар тал
- B. Тэрэлжийн Зуун мод  
E. Шар бэл
- C. Хашин нуур

34. Хутагт хувилгаад, сүм хийдийн мэдэлд захирагдагсад аль давхаргад хамаарах вэ?

/1 оноо/

- A. Хамжлага ард  
D. Шавь ард
- B. Суман ард  
E. А ба В
- C. Ноёд язгууртнууд

35. Дан биеэр очиж хаадаг хилийн харуулын албыг ..... гэнэ. Нөхнө үү.

/2 оноо/

- A. Суман харуул  
D. Суман өртөө
- B. Гэр харуул  
E. Суурь өртөө
- C. Дотоод харуул

36. Дараах түүхэн үйл явдлуудыг зүй тогтлоор нь зөв дараалалд оруулна уу.

/2 оноо/

1. Улиастайг Манж-Хятадаас чөлөөлөв.  
2. Улсын дээд, доод хурал байгуулав.  
3. Орос-Хятадын гэрээ байгуулагдав.  
4. Хиагтын гурван улсын гэрээ байгуулагдав.  
5. Хятадын ерөнхийлөгч Гадаад Монголын автономийг устгав.

- A. 1,3,2,4,5      B. 1,2,3,4,5      C. 5,4,3,2,1  
D. 1,3,5,2,4      E. 2,4,1,3,5

37. 1911 оны Монгол улсын таван яамны сайдуудын хэргэм, цолыг харгалзуулна уу.

/2 оноо/

- A. Хошой Чин ван  
B. Улсад туслагч гүн, засаг  
C. Да лам  
D. Улсын түшээ гүн, Чуулган дарга  
E. Засаг, бэйс
1. Ханддорж  
2. Цэрэнчимэд  
3. Гомбосүрэн  
4. Чагдаржав  
5. Намсрай

- A. a1, b2, c3, d4, e5  
D. a1, b3, c4, d5, e2
- B. a5, b4, c3, d2, e1  
E. a5, b4, c3, d1, e2
- C. a1, b5, c2, d4, e3

38. 1911 оны 12 сарын 29-ний өдөр Богд Жибзундамба хутагтыг хаанд өргөмжилсөн. Улсын нэрийг....., оны цолыг “Олноо өргөгдсөн” хэмээжээ. Нөхнө үү. /1 оноо/  
A. Монгол B. Олноо өргөгдсөн C. Богд хаант улс  
D. Ардын эрхт Монгол улс E. Тохирох хариулт алга
39. Ноёдын бүлгэмийн гишүүдэд аль өгөгдөл хамаарах вэ? /1 оноо/  
A. Д. Бодоо, Д. Чагдаржав, Д. Лосол  
B. М. Хатанбаатар, Дилав хутагт Жамсранжав, Да Лам Пунцагдорж  
C. С. Данзан, Д. Догсом, Ө. Дэндэв  
D. Жалханз хутагт Дамдинбазар, Жонон ван Ширнэндамдин, Ялгуусан лам Найдансүрэн  
E. B ба D
40. Ардын намын цэрэгт Хиагтыг хамгаалах цэргээс болон бусад нутгаас элсэгчдийг ямар цэрэг хэмээн нэрлэдэг байсан бэ? /1 оноо/  
A. Шадар цэрэг B. Цахар цэрэг C. Хошуу цэрэг  
D. Цоохор цэрэг E. Хүрээ цэрэг
41. Богд гэгээнийг төрийн Шар ордонд залж, хэмжээт эрхт хаанаар өргөмжлөн, ардын эрхтэй хэмжээт цаазат засгийг явуулах болсныг хэзээ түмэн олонд тунхаглан зарласан бэ? /1 оноо/  
A. 1920. 7.11 B. 1921. 2.4 C. 1921. 7.11  
D. 1921. 11.5 E. 1922 .1.5
42. 1923 онд Монгол улсын нутгийн захиргааны дүрмийг шинэчлэн баталснаар хуучин Засагт хан аймгийг хэрхэн нэрийдсэн бэ? /1 оноо/  
A. Богд хан уулын аймаг B. Цэцэрлэг мандал уулын аймаг  
C. Хантайшир уулын аймаг D. Дэлгэр Их уулын аймаг  
E. Хан Хэнтий уулын аймаг
43. “МАН-ын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алгасах зорилгод хүрэхээр урагшаа давшин явж байна” гэж Э. Ринчино үзсэн байдаг. Дээрх түүхэн баримтын агуулгад нийцүүлэн хийсэн дүгнэлтэд аль нь хамааралгүй вэ? /2 оноо/  
A. Нийгмийн хөгжлийн үе шат бүрийг алгасахгүйгээр дамжих ёстой.  
B. Намын зорилго бол капитал хөрөнгөтний хөгжлийн зам мөн.  
C. МАН-ын эцсийн зорилт бол эв хамтын ёс мөн.  
D. Э. Ринчино бол хөрөнгөтний бус үзэлтэн.  
E. C ба D хамаарна.
44. “... чадваргүй авч манай бодлогыг баримталж, урвахгүй байх тийм хүн хэрэгтэй” гэж хэн үзэж байсан бэ? /1 оноо/  
A. Б. Шмераль B. Ц. Дамбадорж C. А. Амар  
D. Г. Гэлэгсэнгэ E. Н. Жадамба
45. УБХ-ын Тэргүүлэгчдийн дарга Х. Чойбалсангаар ахлуулж, найман хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан комисс 1929 оны 9 сарын 18-ны өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа эхлэж, орон нутагт 204 хүн томилон ажиллуулжээ. Уг комисс ямар нэртэй байсан бэ? /2 оноо/  
A. Улсын онц эрхт комисс B. Шинэ эргэлтийн бодлогын комисс  
C. Онцгой бүрэн эрхт комисс D. Феодал агсдын хөрөнгө хураах комисс  
E. Цагаатгах комисс
46. 1932 оны зэвсэгт бослогын үеэр босогчид ямар яамыг байгуулсан бэ? /1 оноо/  
A. Очирбатын цэргийн яам B. Лам нарын яам  
C. Шашныг мандуулагч яам D. Самбуугийн яам  
E. Эдгээрээс өөр

47. Монгол улсын АЗГ-ын анхны Ерөнхий сайд Д.Бодоо нарын 14 хүнийг “эх орноосоо урвасан, хаант төрийг сэргээх гэсэн ” хэмээх хилс хэргээр шийтгэжээ. ХХ зууны хэлмэгдүүлэлтийн эхлэл болсон энэ үйл явдал хэзээ болсон бэ? /1 оноо/  
A. 1937. 8.24 B. 1922. 8.30-31 C. 1937.10.2  
D.1937. 9.10 E. 1937.10.18-21
48. Халх голын дайны талаар дурдахдаа алдаа гаргасан бол аль вэ? /2 оноо/  
A. 1936 оны 3 сарын 12-нд БНМАУ, ЗХУ-ын “Харилцан туслалцах протокол гэрээ” Улаанбаатар хотод байгуулсан.  
B. 1936 онд батлан хамгаалах зардлыг 2 дахин, цэргийн тоог 30 хувь нэмэгдүүлж, цэргийн албаны хугацааг гурван жил болгосон.  
C. 1939 оны 8 сарын 31-нд Японы 6-р армийг эх нутгаасаа хөөн гаргасан.  
D. Энэ дайнд Япон, Манж Го-гийн талаас 48000, Монгол-Зөвлөлтийн 26000 хүн амь үрэгдсэн.  
E. Халх голын дайнд С.Дампил, Д.Данзанваанчиг, Л.Аюуш зэрэг БНМАУ-ын баатрууд төрсөн.
49. “Хэрэв энэхүү гэрээ тогтоосон нэгэн этгээдийг цэргийн хүчээр довтолбол бие биедээ элдэв тусламж мөн цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх үүрэгтэй” гэж аль гэрээгээр тогтоосон бэ? /2 оноо/  
A. Төвийг сахих гэрээ B. Харилцан үл довтолох гэрээ  
C. Нэрчүгийн гэрээ D. Харилцан туслалцах протокол гэрээ  
E. Буурын гэрээ
50. 1956 онд “Цэцэг бүхэн дэлгэрэг, эрдэмтэн бүхэн уралдаг” хэмээх уриа гаргаж, улс орны хөгжлийн тухай сэхээтнүүдийн санал бодлыг сонсоод эцэст нь тэдний эсрэг үйл ажиллагааг зохион байгуулсан байдаг. Түүнийг түүхэнд хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/  
A.Сэхээтний төөрөгдөл B. Ангич үзэлтэн C. Намч үзэлтэн  
D. Хөрөнгөтний үзэлтэн E. Марксист үзэлтэн
51. “БНМАУ бол ажилчид, хоршоолсон ардууд, хөдөлмөрийн сэхээтний социалист улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн” гэж аль Үндсэн хуулинд заасан бэ? /2 оноо/  
A. 1924 оны Үндсэн хууль B.1940 оны Үндсэн хууль  
C.1960 оны Үндсэн хууль D. 1992 оны Үндсэн хууль  
E.1940 оны Намын Х их хурал
52. Социализмын үеийн нийгмийн амьдралын үзэл суртлын хүрээнд хамаарах өгөгдлийг дурдахдаа алдаа гаргасан бол олно уу? /2 оноо/  
A. Марксизм-Ленинизм хэмээх цорын ганц онол  
B. Мэдээлэл нээлттэй бус хариуцлагын механизм тааруу  
C. Шүтэх, эс шүтэх эрх чөлөөг боомилсон.  
D. Хэвлэн нийтлэх, үг хэлэх эрх, эрх чөлөө хаагдмал  
E. Олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжсэн.
53. “Маршал Чойбалсан”, “Жанжин Сүхбаатар” зэрэг уран баримал хэний бүтээл вэ? /1 оноо/  
A. Л.Дашдэлэг B. А.Даваацэрэн C. С.Чоймбол  
D. Б. Шарав E. О.Цэвэгжав
54. 1992 оны 1 сарын 13-нд Монгол улсад түүхэн ямар чухал үйл явдал болсон бэ? /2 оноо/  
A. Нам төрийн удирдлага ба шинэ хүчний удирдагчдын оролцсон “Дугуй ширээний ярилцлага” болов.  
B. Монголын ардчилсан холбоо байгуулагдав.  
C. Монгол улсын шинэ Үндсэн хууль батлав.  
D.Монгол улсад анх удаа олон намын оролцоотой чөлөөт ардчилсан сонгууль болов.  
E. Монголын ардчилсан холбооны гишүүд, дэмжигчид улс төрийн өлсгөлөн зарлав.

55. Үнэ чөлөөлөх анхны зоримог алхмыг 1991 оны 1 сард хэний Засгийн газар хийсэн бэ? /2 оноо/

А. Д.Бямбасүрэнгийн Засгийн газар  
С. Ц.Элбэгдоржийн Засгийн газар  
Е. Р. Амаржаргалын Засгийн газар

В. П.Жасрайн Засгийн газар  
D. Ж.Наранцацралтын Засгийн газар

56. Монгол улсын шинэ Үндсэн хуулинд нийгмийн хөгжлийн чиг хандлагыг хэрхэн томъёолсон бэ?

/2 оноо/

А. Иргэний, хүмүүнлэг ардчилсан  
С. Ардчилсан, иргэний хүмүүнлэг  
Е. Ардчилсан, хүмүүнлэг иргэний

В. Хүмүүнлэг, иргэний ардчилсан  
D. Хүмүүнлэг, ардчилсан иргэний

### ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

1. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
2. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Монголын түүх, археологийн дараах дурсгалууд олдсон газрыг одоогийн аймаг нутгаар нь тохируулан нэрлэнэ үү. /5 оноо/

А.Хойд цэнхэрийн агуйн хадны зураг /палеолит/  
В. Цагаан агуй /палеолит/  
С. Чандманы соёл /Хүннү/  
D. Культегиний гэрэлт хөшөө  
Е. Хэрлэнбарс хотын суврага /Хятан/

2.2. Дараах ойлголтуудыг түүхэн утгаар нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

А. Хадны сүг зураг  
В. Хиргисүүр  
С. Буган хөшөө  
D. Дөрвөлжин булш  
Е. Морин тэрэг

1. Оройн хэсэгт нь нар, сар, ээмэг дүрсэлнэ.  
2. НТӨ XVI-VI зууны үед Монголын төв ба баруун хэсэгт оршин суугчдын соёл  
3. Амьтдыг бодит ба загварчлан дүрслэх аргаар дүрсэлнэ.  
4. НТӨ II мянганд хамаарах ба Монгол нутгаас 100 орчим олдсон.  
5. Нүхээ хавтгай чулуугаар доторлож, шарилынхаа толгой дор чулуу дэрлүүлэн дээш харуулна.

2.3. Дараах хаадуудыг төр барьж байсан он цагийн дарааллаар нь эрэмбэлнэ үү. /1-5 хүртэл дугаарлана./

/5 оноо/

А. Чингис .....  
В. Хубилай .....  
С. Өгөөдэй .....  
D. Мөнх .....  
Е. Гүюг .....

2.4. Дараах өгөгдлийг цаг хугацаатай нь зөв харгалзуулна уу.

/5 оноо/

А. Хүннү улс байгуулагдав.  
В. Хүннү, Хан улсын хооронд гэрээ байгуулав.  
С. Сяньби улс оршин тогтносон.  
D. Жужан улс оршин тогтносон.  
Е. Хятан улс оршин тогтносон.

1. НТ I-III зуун  
2. НТ 330-555 он  
3. НТ 901-1125  
4. НТӨ 198 он  
5. НТӨ 209 он